БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

**Булган аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: БУА-2022/108/НА-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас:
www.audit.mn

Булган хот

2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ........................................ 2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 4
3. Аудитын тайлан ........................................ 14
   3.1 Ерөнхий зүйл ........................................ 14
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................ 14
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 15
   3.4 Материаллаг байдал ........................................ 15
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................ 16
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................ 16
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................ 17
   3.8 Аудитын гол асуудал ........................................ 18
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................ 18
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 19
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................ 19
4. Аудитын илрүүлэлт ........................................ 19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................ 21


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын оргон чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 115

танай ________ ны № ________ т

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА Л.ГАНБААТАР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\bichigheregi\2022\Albot

006020217

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:\bichighereg\2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **252,392,946.67** | **244,342,211.29** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **252,392,946.67** | **244,342,211.29** |
| 351 | Түүхий эд материал | 121,898,059.13 | 105,339,419.75 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 119,482,309.13 | 96,274,099.75 |
| 35130 | Эм боох материал | 2,415,750.00 | 9,065,320.00 |
| 354 | Хангамжийн материал | 107,633,037.54 | 114,145,180.54 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 28,303,704.00 | 14,923,325.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,984,300.00 | 4,018,800.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,245,500.00 | 18,351,600.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 9,282,187.00 | 6,064,187.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,440,835.00 | 2,861,705.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,263,308.00 | 13,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 59,113,203.54 | 67,912,063.54 |
| 35600 | Мал, амьтад | 22,861,850.00 | 24,857,611.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,486,676,124.40** | **2,457,582,868.72** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,486,676,124.40** | **2,457,582,868.72** |
| 392 | Биет хөрөнгө | 2,364,404,584.48 | 2,289,292,412.02 |
| 39201 | Барилга, байгууламж | 1,806,377,830.91 | 1,825,139,492.44 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (73,642,171.27) | (113,177,225.11) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 302,820,835.04 | 417,805,609.56 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (147,585,686.67) | (199,763,859.39) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 523,329,384.08 | 545,867,712.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (134,036,560.74) | (288,125,178.68) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,427,210.50 | 61,258,452.78 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (22,864,804.79) | (23,809,101.30) |
| 39211 | Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж | 49,320,200.00 | 49,320,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 23,608,005.00 | 21,619,905.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (8,349,657.58) | (6,843,595.98) |
| 393 | Биет бус хөрөнгө | 122,271,539.92 | 168,290,456.70 |
| 39301 | Програм хангамж | 1,025,000.00 | 850,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (512,500.08) | (114,583.30) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 121,759,040.00 | 167,555,040.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,739,069,071.07** | **2,701,925,080.01** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **2,739,069,071.07** | **2,701,925,080.01** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,739,069,071.07 | 2,701,925,080.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 1,110,542,957.28 | 1,156,338,957.28 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 1,110,542,957.28 | 1,156,338,957.28 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,029,058,643.18 | 946,118,652.12 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,029,058,643.18 | 1,029,058,643.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (82,939,991.06) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 599,467,470.61 | 599,467,470.61 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **2,739,069,071.07** | **2,701,925,080.01** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,693,180,762.82** | **2,829,468,516.70** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **309,590,502.82** | **210,032,366.70** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 299,590,502.82 | 210,032,366.70 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 232,749,359.00 | 54,131,471.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,650,000.00 | 18,868,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 218,099,359.00 | 35,263,471.00 |
| 120017 | үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 40,754,821.32 | 141,123,535.20 |
| 12001701 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө /Цагдаа/ | 22,095,021.32 | 141,123,535.20 |
| 12001702 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө /Бусад/ | 18,659,800.00 | - |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 26,086,322.50 | 14,777,360.50 |
| 12001801 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал /Цагдаа/ | 25,386,322.50 | 14,777,360.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 12001802 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал /Бусад/ | 700,000.00 | - |
| 122 | Тусламжийн орлого | 10,000,000.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 10,000,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,383,590,260.00** | **2,619,436,150.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,314,540,600.00 | 2,553,224,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,314,540,600.00 | 2,553,224,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 69,049,660.00 | 66,211,250.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 2,342,500.00 | 3,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 66,707,160.00 | 62,711,250.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **2,720,057,933.79** | **2,905,502,133.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,720,057,933.79** | **2,905,502,133.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,710,696,097.79** | **2,895,944,432.46** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,921,550,543.00 | 2,170,001,384.00 |
| 210101 | Цалин | 1,921,550,543.00 | 2,170,001,384.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,059,598.00 | 47,675,116.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 3,937,023.00 | 3,770,227.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 426,788.00 | 370,209.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 367,476.00 | 330,916.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 75,233.00 | 66,575.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 38,253,078.00 | 43,137,189.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 120,288,319.00 | 123,396,200.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 11,233,525.00 | 12,347,100.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 98,541,180.00 | 100,524,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 10,513,614.00 | 10,524,900.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 148,702,277.20 | 188,575,883.40 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 12,944,855.20 | 13,335,549.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 120,246,364.00 | 128,922,750.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 8,956,378.00 | 7,657,320.00 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал | 53,060.00 | 103,060.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 385,600.00 | 356,100.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 3,778,700.00 | 4,469,600.00 |
| 210408 | Бараа материал актасны зардал | 2,337,320.00 | 33,731,504.40 |
| 2105 | Нормативт зардал | 24,267,050.00 | 13,419,600.00 |
| 210501 | Эм | 290,700.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол | 23,100,350.00 | 13,419,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 876,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 53,888,310.00 | 37,488,298.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 2,762,700.00 | 5,554,838.00 |
| 210604 | Урсгал засвар | 51,125,610.00 | 31,933,460.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 23,985,100.00 | 22,321,000.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 23,985,100.00 | 22,321,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 12,122,324.00 | 6,576,195.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,000,000.00 | 3,834,525.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,305,000.00 | 1,805,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | 407,000.00 | 420,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 232,100.00 | 232,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягтын зардал | 178,224.00 | 284,570.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 362,832,576.59 | 286,490,756.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,258,040.00 | 4,372,803.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 3,664,847.80 | 2,128,946.70 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 352,909,688.79 | 279,989,006.36 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,361,836.00 | 9,557,701.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,260,000.00 | 6,612,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 1,416,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 4,760,000.00 | 5,196,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,101,836.00 | 2,945,701.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,101,836.00 | 2,945,701.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **(26,877,170.97)** | **(76,033,616.76)** |
| 225 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | - | **6,906,374.30** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 4,819,874.30 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал /бараа материал/ | - | 2,086,500.00 |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | - | **(6,906,374.30)** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **(26,877,170.97)** | **(82,939,991.06)** |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,398,240,260.00** | **2,638,304,150.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **14,650,000.00** | **18,868,000.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 14,650,000.00 | 18,868,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 14,650,000.00 | 18,868,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,650,000.00 | 18,868,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,383,590,260.00** | **2,619,436,150.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,314,540,600.00 | 2,553,224,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,314,540,600.00 | 2,553,224,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 69,049,660.00 | 66,211,250.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 2,342,500.00 | 3,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 66,707,160.00 | 62,711,250.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **2,348,423,050.00** | **2,607,197,730.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,348,423,050.00** | **2,607,197,730.00** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,339,061,214.00** | **2,597,392,029.00** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,921,670,100.00** | **2,170,001,384.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,079,519,700.00 | 1,179,867,884.00 |
| 210102 | Нэмэгдэл | 842,150,400.00 | 990,133,500.00 |
| **2102** | **Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл** | **43,059,597.00** | **47,675,116.00** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 43,059,597.00 | 47,675,116.00 |
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **120,288,319.00** | **123,396,200.00** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 11,233,525.00 | 12,347,100.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 98,541,180.00 | 100,524,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 10,513,614.00 | 10,524,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **144,142,268.00** | **153,639,749.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 17,803,740.00 | 10,831,009.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 111,666,300.00 | 122,209,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,046,578.00 | 8,063,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 53,060.00 | 103,060.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 397,600.00 | 635,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,174,990.00 | 11,797,280.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **25,824,150.00** | **13,725,000.00** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 449,350.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,565,000.00 | 13,425,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,809,800.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 42,647,580.00 | 56,357,930.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | - | 1,076,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | 3,998,700.00 | 2,980,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 38,648,880.00 | 52,301,230.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **23,985,100.00** | **22,321,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,985,100.00 | 22,321,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,944,100.00** | **6,290,800.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 10,000,000.00 | 3,833,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,305,000.00 | 1,805,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 407,000.00 | 420,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 232,100.00 | 232,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,500,000.00** | **3,984,850.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,050,000.00 | 2,485,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 2,450,000.00 | 1,499,850.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,361,836.00** | **9,805,701.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,260,000.00 | 6,860,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 4,760,000.00 | 5,360,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,101,836.00 | 2,945,701.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,101,836.00 | 2,945,701.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **49,817,210.00** | **31,106,420.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **49,817,210.00** | **31,106,420.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,817,210.00** | **31,106,420.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 49,817,210.00 | 31,106,420.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 49,817,210.00 | 31,106,420.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(49,817,210.00)** | **(31,106,420.00)** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **1,110,542,957.28** | **600,963,642.87** | **1,054,439,641.89** | **2,765,946,242.04** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 1,496,172.26 | 1,496,172.26 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,110,542,957.28 | 600,963,642.87 | 1,055,935,814.15 | 2,767,442,414.30 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | | | | |
| Хөрөнгө оруулалтын | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| дахин үнэлгээний гарз | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | (26,877,170.97) | (26,877,170.97) |
| 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,110,542,957.28 | 599,467,470.61 | 1,029,058,643.18 | 2,739,069,071.07 |
| **2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,110,542,957.28** | **599,467,470.61** | **1,029,058,643.18** | **2,739,069,071.07** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,110,542,957.28 | 599,467,470.61 | 1,029,058,643.18 | 2,739,069,071.07 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 45,796,000.00 | | | 45,796,000.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | (82,939,991.06) | (82,939,991.06) |
| **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,156,338,957.28** | **599,467,470.61** | **946,118,652.12** | **2,701,925,080.01** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 2 | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,569,224,900.00** | **2,569,147,199.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **2,569,224,900.00** | **2,569,147,199.00** |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 2,562,364,900.00 | 2,562,287,199.00 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,169,990,800.00** | **2,169,990,800.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,179,857,300.00 | 1,179,857,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 990,133,500.00 | 990,133,500.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **46,605,800.00** | **46,605,800.00** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 46,605,800.00 | 46,605,800.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **123,396,200.00** | **123,396,200.00** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 12,347,100.00 | 12,347,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 100,524,200.00 | 100,524,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,524,900.00 | 10,524,900.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **140,435,300.00** | **140,391,049.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,468,000.00 | 8,465,709.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 115,823,800.00 | 115,823,800.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 8,063,500.00 | 8,063,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 103,060.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660,000.00 | 635,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 7,300,000.00 | 7,299,280.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **13,725,000.00** | **13,725,000.00** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | 300,000.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,425,000.00 | 13,425,000.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 40,020,000.00 | 39,986,700.00 |
| 210603 | **Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл** | **3,000,000.00** | **2,980,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 37,020,000.00 | 37,006,200.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **20,401,000.00** | **20,401,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,401,000.00 | 20,401,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **6,290,800.00** | **6,290,800.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,833,700.00 | 3,833,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,805,000.00 | 1,805,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 420,000.00 | 420,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 232,100.00 | 232,100.00 |
| 2201 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,500,000.00** | **1,499,850.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,500,000.00 | 1,499,850.00 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,860,000.00** | **6,860,000.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,860,000.00 | 6,860,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 5,360,000.00 | 5,360,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,569,224,900.00** | **2,572,092,900.00** |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,553,224,900.00** | **2,553,224,900.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,553,224,900.00 | 2,553,224,900.00 |
| 120004 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **16,000,000.00** | **18,868,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,000,000.00 | 18,868,000.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 145.00 | 141.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 141.00 | 136.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 4.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | - | - |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **66,211,250.00** | **66,211,250.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **66,211,250.00** | **66,211,250.00** |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 66,211,250.00 | 66,211,250.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **10,584.00** | **10,584.00** |
| 210101 | Үндсэн цалин | 10,584.00 | 10,584.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,069,316.00** | **1,069,316.00** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,069,316.00 | 1,069,316.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,260,700.00** | **14,260,700.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,365,300.00 | 2,365,300.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 6,385,400.00 | 6,385,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 5,510,000.00 | 5,510,000.00 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **46,465,650.00** | **46,465,650.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 27,903,350.00 | 27,903,350.00 |
| 210602 | Тавилга | 2,145,000.00 | 2,145,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,417,300.00 | 16,417,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,920,000.00** | **1,920,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,920,000.00 | 1,920,000.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,485,000.00 | 2,485,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,485,000.00 | 2,485,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **66,211,250.00** | **66,211,250.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 66,211,250.00 | 66,211,250.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 62,711,250.00 | 62,711,250.00 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 145.00 | 141.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 141.00 | 136.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 4.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Цагдаагийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 30/01-213 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган аймаг дахь Цагдаагийн газар нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн зорилт, хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжилтийг хангах, хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг агентлаг.

Удирдлага, Захиргааны удирдлагын тасаг, Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Шуурхай удирдлагын тасаг, Хутаг-Өндөр сум дахь сум дундын цагдаагийн тасаг, Рашаант сум дахь сум дундын цагдаагийн тасаг, Хангал сум дахь сум дундын цагдаагийн тасаг, Бүрэгхангай сум дахь сум дундын цагдаагийн тасаг гэсэн бүтэц, 145 алба хаагчийн орон тоотойгоор аймгийн 16 сум, 1 тосгон, 75 баг, 61516 иргэнд хүрч үйлчлэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд 2 зорилгыг дэвшүүлэн ажилласан байна

- Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдэг ур чадварыг дээшлүүлж аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах
- Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангах

Булган аймаг дахь цагдаагийн газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 37 заалт бүхий төлөвлөгөө гарган 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2021 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргав. Зорилго: Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Цагдаагийн газрын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр 92.2 хувь буюу 4.5 оноогоор үнэлэгдсэн байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Цагдаагийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 2,553,224.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,532.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,872.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,093.2 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | |
| Бараа материал | 252,392.9 | 244,342.2 | ( 8,050.7 ) |
| Үндсэн хөрөнгө | 2.486.676.1 | 2,457,582.9 | ( 29,093.2 ) |
| **Нийт хөрөнгө** | **2,739,069.1** | **2,701,925.1** | **( 37,144.0 )** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,739,069.1 | 2,701,925.1 | 37,144.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,739,069.1** | **2,701,925.1** | **37,144.0** |

Бараа материалын данс 244,342.2 мянган төгрөг болж 8,050.7 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал, хангамжийн материалын зарцуулалтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,457,582.9 мянган төгрөг болж 29,093.2 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг сунгаж дахин үнэлсэн, 3 тээврийн хэрэгсэл 28 нэр төрлийн үндсэн хөрөнгө акталж устгаснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,701,925.1 мянган төгрөг болж 37,144.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймаг дахь Цагдаагийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 136,287.8 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар, нийт зардал өмнөх оноос 165,444.2 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар тус тус өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг дахь Цагдаагийн газар нь 2021 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын зардал болон цэргийн байнгын тэтгэвэрт гарах алба хаагчдад олгох нэг удаагийн тэтгэвэр тэтгэмжийг оролцуулан тооцож зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,173,178.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,173,178.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 1,507,485.2 мянган төгрөгөөр буюу тэтгэвэр тэтгэмж, хөрөнгө оруулалтын зардлыг бууруулан 2.665.692.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 3 удаа тодотгол хийж 96,467.9 мянган төгрөгөөр бууруулж, 2,569,224.9 мянган төгрөгөөр баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Булган аймаг дахь цагдаагийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 2,553,224.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 18,868.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжиж урсгал үйл ажиллагаанд 2,569,147.2 мянган төгрөгийг зарцуулж, 2,945.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 77.7 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг 44.3 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 33.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.2 мянган төгрөг, хангамж, дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвөөс 10,078.6 мянган төгрөгийн давсан орлого, АЗДТГазраас 52,632.9 мянган төгрөгийн санхүүжилт, Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,500.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 1,079.9 мянган төгрөгийн байгууллагад өгөх өглөгийг барагдуулж, канабис устгах зардалд /шатахуун, албан томилолт/ 7,000.0 мянган төгрөгийг, замын хяналтын пост, сургалтын нэгдсэн төвийн засварын зардалд 18,423.0 мянган төгрөгийг, урьдчилан сэргийлэх зардалд 22,850.7 мянган төгрөгийг, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 16,857.7 мянган төгрөгийг тус тус зарцуулж санхүүжилт олгосон байгууллагуудад зарцуулалтын тайланг тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн Цалингийн хүснэгтээрх цалин, Нийгмийн даатгалын тайлангаарх цалин 400.0 мянган төгрөгөөр зөрүүтэй. Энэ нь 8 сард Нийгмийн даатгалын тайланд М.Отгонбаатар, Д.Шинэдаваа нарын нэр дээр 400.0 мянган төгрөг илүү тайлагнасан байна. Шилэн дансанд 1, 8 сард нийт 12 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 3 нэр төрлийн 9 590.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажаагүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 484.2 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. 1 дүгээр сард Х.Баттулгат цалингийн 20%-иар сахилгын шийтгэлийн арга хэмжээ авсан боловч 2 сард сахилгын шитгэлийн 114.3 мянган төгрөгийг суутгаагүй байна зэрэг алдаанууд илэрсэн байна.

### 3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх 139 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, ковид цар тахлын тусгаарлалтанд байсан шалтгаанаар 8 дугаар сарын хугацаа хоцроосон 12 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны мэдээлэл 92 хувьтай хэрэгжсэн байна.

Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажаагүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна. Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших. Цалингийн тооцооллыг зөв хийж НДШ-ийн тайлан, цалингийн хүснэгт, ХХОАТ-ын тайлангуудыг тулган үнэн зөв тайлагнаж байх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул зөвлөмж өглөө.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2,632.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 231.8 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Акт | - | - | - | - | | | |
| Албан шаардлага | - | | - | | | | |
| Зөвлөмж | 5 | 14,688.3 | 5 | 14,688.3 | | | |
| Нийт дүн | 5 | 14,688.3 | 5 | 14,688.3 | | | |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх, цалингийн тооцооллыг зөв хийж НДШ-ийн тайлан, ХХОАТ-ын тайлангуудыг тулган үнэн зөв тайлагнаж хэрэгжүүлэх бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 884.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 884.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

**4.2 Акт**

Аудитын явцад акт байхгүй.

**4.3 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлэх хэмжээний алдаа зөрчил гаргаагүй болно.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1 <u>Илрүүлэлт:</u>*

Цалингийн хүснэгтээрх цалин, Нийгмийн даатгалын тайлангаарх цалин 400.0 мянган төгрөгөөр зөрүүтэй. Энэ нь 8 сард Нийгмийн даатгалын тайланд М.Отгонбаатар, Д.Шинэдаваа нарын нэр дээр 400.0 мянган төгрөг илүү тайлагнасан байна.

1.2 *Өгсөн зөвлөмж:*

Цалинг бодохдоо тооцооллыг зөв хийж НДШ-ийн тайлан, цалингийн хүснэгт, ХХОАТ-ын тайлангуудыг тулган үнэн зөв тайлагнаж байх

***2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*2.1 Илрүүлэлт:*

Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажаагүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 484.2 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

2.2 *Өгсөн зөвлөмж:*

*Анхан шатны баримтыг хууль, дүрмийн* дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших

***3 Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал***

*3.1 Илрүүлэлт:*

Шилэн дансанд 1, 8 сард нийт 12 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*3.2 Өгсөн зөвлөмж:*

Хуулийн хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Булган аймаг дахь Цагдаагийн газар | 3 | 884.2 | | | | | | | 3 | 884.2 |
| | Дүн | 3 | 884.2 | | | | | | | 3 | 884.2 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР: Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР,ЗАХИРАЛ : Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.АНХБАЯР